



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 21 өдөр

Дугаар A788

Улаанбаатар хот

**Газар эзэмших эрхийн
талбайн хэмжээг өөрчлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.7 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/253 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эзэмшиж буй газрын талбайн хэмжээг өөрчлүүлэх хүсэлт ирүүлсэн 1 (нэг) аж ахуйн нэгж байгууллагын газрын талбайн хэмжээг хавсралтад зааснаар баталгаажуулсугай.

2. Эзэмшиж буй газрын талбайн хэмжээ өөрчлөгдөж байгаа аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2012 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/11 дүгээр захирамжийг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД